

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Санхүүгийн хяналт шалгалт 2023, 2024 оны үйл ажиллагаа  
Хамрагдсан байгууллага: Хот тохижилтын газар ОНӨААТҮГ

Улаанбаатар хот  
2025 он

## АГУУЛГА

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b> .....	2
<b>ТАНИЛЦУУЛГА</b> .....	4
<b>ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ</b> .....	5
<b>ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН</b> .....	6
<i>Зорилт 1. Засаглалын талаар</i> .....	6
<i>Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар</i> .....	8
<i>Зорилт 3. Худалдан авах ажиллагааны талаар</i> .....	15
<b>ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ</b> .....	16
<b>ДҮГНЭЛТ</b> .....	19
<b>ЗӨВЛӨМЖ</b> .....	19

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
НЗД	Нийслэлийн Засаг дарга
КУГ	Картын удирдлагын газар
НХААГ	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НИТХТ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НАЗХГ	Нийслэлийн авто замын хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ЦДТХЦ	Цагаан давааны төвлөрсөн хогийн цэг
НӨАУГ	Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХАБЭА	Хөдөлмөр аюулгүй байдлыг эрхлэх алба
ТҮА	Тохижилт үйлчилгээний алба
НБА	Ногоон байгууламжийн алба
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НТША	Нээлттэй тендер шалгаруулалтын арга
ШХА	Шууд худалдан авалт
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХА	Харьцуулалтын арга
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн (НИТХТ) 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ татан буулгаж, “Хот тохижилтын газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (ОНӨААТҮГ) байгуулж, тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дүрмийг баталсан байна. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04, 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/392 дугаар захирамжаар Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тоог тус тус шинэчлэн баталсан байна.

Тус дүрмээр “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ нь Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, төвлөрсөн хогийн цэгүүдэд хог хаягдлыг технологийн дагуу хөрсөөр дарж булах, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, тохижуулалт, цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлт, нийтийн эзэмшлийн гудамж, автозам, явган зам, талбайг цэвэрлэгээ үйлчилгээ, тохижилт, хөшөө дурсгалын цогцолбор газрын засвар, арчлалт, эзэнгүй нохой, муурын устгалыг хариуцан гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн” гэж баталжээ.

Тус ОНӨААТҮГ нь Эрхэм зорилгоо “Нийслэл хотын иргэдийн ая тухтай, эрүүл орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг хангаж хотын өнгө төрхийг орчин үеийн хөгжлийн өндөр түвшинд хүргэнэ”, Алсын хараагаа “Хөгжилд хүрсэн-хот тохижилт”, Зорилго “Нийслэлчүүдэд тохижилт ногоон байгууламж, нийтийн үйлчилгээг хөгжлийн өндөр түвшинд хүргэнэ” гэж тус тус тодорхойлжээ.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд хамтын гэрээг байгуулж, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2019 оны 07 дугаар сарын 01-ний А/64 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/13, 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/20 дугаар тушаалуудаар тус тус Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилсэн байна.

НЗД-ын 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Б/184 дүгээр захирамжаар Б.Мөнхцэцэгийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргаар томилж, 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн Б/98 дугаар тушаалаар чөлөөлж, НЗД-ын 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн Б/99 дүгээр захирамжаар Г.Ууганбаярыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргаар томилж, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/566 дугаар тушаалаар Б.Оюунсүрэнг санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчоор томилж, 2025 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн Б/123 дугаар тушаалаар чөлөөлж, 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/135 дугаар тушаалаар Б.Даваасүрэнг санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилж, 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн Б/151 дүгээр тушаалаар санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчоор томилсон байна.

Шалгалтад хамрагдах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Б.Мөнхцэцэг, хоёрдугаар гарын үсгийг санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Оюунсүрэн нар зурж ХААН банкн дахь орлогын данс, ХХБанкны үндсэн үйл ажиллагааны дансаар бэлэн бус төлбөр тооцоог хийж, хөрөнгө, мөнгийг захиран зарцуулсан байна.

Өмнөх шалгалтын талаар:

Тус газрын 2023 оны санхүүгийн тайланд Нийслэл дэх Төрийн аудитын газрын

шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт хүргүүлсэн байна. Аудитаар нийт 55,187.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 21,090.9 мянган төгрөгийн албан шаардлага, 34,096.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

2024 оны санхүүгийн тайланд Нийслэл дэх Төрийн аудитын газрын шалгалтаар өөрчлөлтгүй санал дүгнэлт хүргүүлсэн байна. Аудитаар нийт 225,369.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,927.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 63,662.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 155,780.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

Нийслэлийн Дотоод аудитын албанаас тус газрын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийж байгууллагын засаглалтай холбоотой илэрсэн асуудалд 2 зөвлөмж, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 203,570.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 16,101.9 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 88,073.2 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

## **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ**

### **Аудит хийх үндэслэл, бүрэлдэхүүн**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1. “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, нийслэлийн Дотоод аудитын албаны “Аудит, хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”, НЗД-ын баталсан 10 дугаар сарын 07-ны өдрийн 14 дүгээр удирдамжийн дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2023, 2024 оны үйл ажиллагаанд Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д. Мөнхханд, дотоод аудитор А.Гэрлээ нар хамтран дотоод аудит, хяналт шалгалтыг 2025 оны 10 дугаар сарын 08-ний өдрөөс эхлэн ажлын 25 хоногт багтаан хийж гүйцэтгэлээ.

### **Зорилго**

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын засаглалын үйл явцын үр нөлөөтэй байдал, төсөв, санхүү, өмч хөрөнгө, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

### **Хамрах хүрээ**

#### **Хяналт шалгалт:**

Санхүүгийн хяналт шалгалтад 2023 он, 2024 оны дараах үйл ажиллагааг хамруулан шалгалаа. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт олгосон байдал;

- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал, тооллого, тооцоо бодолт;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Дээд шатны төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ногдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал;
- Байгууллагын авлага, өр төлбөрийн үүссэн байдал, барагдуулалт, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэх;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, түүнтэй холбоотой үйл ажиллагааны гүйцэтгэл;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Өмнө хийгдсэн шалгалт, акт, албан шаардлага, зөвлөмжийн барагдуулалт;

### **ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН**

#### *Зорилт 1. Засаглалын талаар*

*Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн даргын А/14 дүгээр тушаалаар 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, баталсан байна.

Тус төлөвлөгөөнд стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, биелэлт, тайлагнах үйл ажиллагааг мөн стратеги төлөвлөгөөг тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган биелэлтийг гаргаж, хэрэгжилт, үр дүнг жил бүр тайлагнан, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хэрэгжилтэд хяналт тавьж Захиргаа хүний нөөцийн дарга хариуцна, тус үр дүнг үндэслэн стратеги төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, тодотгол хийх санал боловсруулж ОНӨААТҮГ-ын даргад танилцуулж удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэнэ гэж баталсныг хэрэгжүүлэн ажилласан байна. Тус байгууллага нь стратеги төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнасан.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь 2023, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна.

Нийслэлийн тохижилт ногоон байгууламж, нийтийн үйлчилгээтэй холбоотой 5 стратеги зорилт, 2 төсөл хөтөлбөр, 69 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99.8 хувийн гүйцэтгэл тайлагнасан байна.

*Тушаал шийдвэрийн талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга 2023 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр А тушаал 80, боловсон хүчний чиглэлээр Б тушаал 457, 2024 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр А тушаал 69, боловсон хүчний чиглэлээр Б тушаал 275 тус тус гаргасан байна.

*Бүтэц, орон тооны талаар:*

НЗД-ын 2023 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 04 дүгээр захирамжаар Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан.

Бүтэц орон тоогоор удирдлага /Дарга, Ерөнхий инженер/ 2, 5 хэлтэс, 5 алба, 1 авто бааз нэгж нийт 605 албан хаагчтай байхаар баталсныг мөрдөн ажиллаж байсан.

НЗД-ын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Чиг үүрэг шилжүүлэх тухай А/1461

дүгээр захирамжаар чиг үүргийн хамаарлыг оновчтой хуваарилах зорилтын хүрээнд зарим чиг үүргийг дүүрэгт шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан байна.

Мөн Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/293 дугаар тушаалаар чиг үүрэг шилжүүлэх ажлын хэсэг байгуулагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зарим чиг үүргийг дүүргүүдэд шилжүүлэн ажиллаж эхэлсэн байна.

НЗД-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/392 дугаар захирамжаар Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, 1 удирдлага, 4 хэлтэс, 2 алба, 1 авто бааз, нийт 173 албан хаагчтай байхаар баталсныг мөрдөж ажиллаж байна.

Хүснэгт 1. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тооны гүйцэтгэл

№	Хэлтэс, алба	НЗД-ын 2023 оны А/04 захирамж		НЗД-ын 2024 оны А/392 захирамж	
		баталсан	гүйцэтгэл	баталсан	гүйцэтгэл
1	Удирдлага /дарга, орлогч дарга, ерөнхий инженер/	2	2	1	1
2	Захиргаа хүний нөөцийн хэлтэс	14	14	8	7
3	Санхүү, бүртгэлийн хэлтэс	10	10	9	9
4	Эдийн засаг, хангамжийн хэлтэс	5	4		
5	Дотоод хяналтын хэлтэс	5	5	7	7
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс	16	16		
7	Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын хэлтэс	4	4	3	3
8	Тохижилт үйлчилгээний алба	200	172	38	36
9	Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба	76	64	70	67
10	Ногоон байгууламжийн алба	128	120		
11	Шуурхай үйлчилгээний алба	30	19		
12	Авто бааз	115	96	37	34
13	Жирэмсэн амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй ажилчид		6		4
<b>Нийт</b>		<b>605</b>	<b>532</b>	<b>173</b>	<b>168</b>

Бүтэц орон тоо шинэчлэн баталсантай холбоотойгоор тус газрын Санхүү, бүртгэлийн хэлтэс, Эдийн засаг хангамжийн хэлтэс нэгдэн Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтэс болж орон тоо 9, Дотоод хяналтын хэлтэс, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс нэгдэн Дотоод хяналт, ХАБЭА-н хэлтэс болж орон тоо 7 болсон байна.

Чиг үүргийн дагуу албадууд нь дараах ажлыг хийж ажилласан байна. Үүнд:

Тохижилт үйлчилгээний алба нь Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй хийсэн гэрээний дагуу 2023 онд 185.8 км, 2024 онд 144 км нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ;

Ногоон байгууламжийн алба нь нийслэлийн хэмжээнд 46 гудамжны 46 га нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн ногоон байгууламжийг хариуцан ажиллах;

Авто бааз нь зам цэвэрлэгээний, хог болон ачаа тээврийн, бохирын, тусгай зориулалтын, усалгааны зориулалттай камаз, ковш, трактор, эксковатор, бобкат, үйлчилгээний, зам цэвэрлэгээний бага оврын техник, мод суллагч зэрэг авто машин, механизмын засвар үйлчилгээ, бэлэн байдлыг хангах;

Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба нь Нийслэлийн 6 дүүргийн аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэд болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэг, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэг, Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгүүдэд 24 цагийн турш хүлээн авч, ландфилл технологийн дагуу хөрсөөр дарж булаах;

Шуурхай үйлчилгээний алба нь газрын өмч хөрөнгөтэй холбоотой засвар үйлчилгээ, тохижилтын ажил, эвдрэл гэмтэл, нийтийн бие засах газар, тамхины цэг, хашаа хайс,

сандал, хогийн савны арчлалт, хамгаалалтыг хариуцан, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах;

*Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын удирдлагын зөвлөл нь 2023 онд 1 удаа, 2024 онд 3 удаа тус тус хуралдаж холбогдох шийдвэрийг гаргаж ажилласан байна.

НИТХ-ын 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Журам, гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай 54 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам, удирдах зөвлөлийн ажиллах журам, захиралтай контракт гэрээ байгуулах, дүгнэх журам зэргийг баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтийг хийсэн байна. Үүнд:

Хүснэгт 2.

Төлөөлөн удирдах зөвлөл

д/д	НИТХ-ын тогтоол					
	Томилогдсон			Чөлөөлөгдсөн		
	Огноо	Дугаар	Нэр	Огноо	Дугаар	Нэр
1	2023.05.01	53	М.Халтар	2023.03.30	24	Л.Одхүү
2	2024.02.08	23	Л.Ариунтуяа	2023.12.05	131	Д.Пүрэвдаваа
3			Г.Батжаргал			Д.Ихбаяр
4			Б.Загарсүрэн	2024.02.08	22	П.Ганзориг
5	2024.12.04	24/17	Л.Хосбаяр	2024.07.24	101	Л.Ариунтуяа
6			Л.Ариунтуяа			Б.Нэргүй
7			Б.Загарсүрэн			
8			М.Халтар			
9			Г.Батжаргал			

### Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

*Санхүүгийн тайлангийн талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн байдлын тайланд нийт 23,243,325.0 мянган төгрөгийн, 2024 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн байдлын тайланд нийт 20,640,879.2 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдлийг тус тус тайлагнасан байна.

Хүснэгт 3.

Санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023.01.01	2023.12.31	2024.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,875,121.8	165,180.3	1,988,357.6
Дансны авлага	262,219.5	21,902.2	21,614.7
Татвар, НДШ-ийн авлага	126,537.1	4,499.9	2,986.4
Бусад авлага		4,317.3	
Урьдчилж төлсөн зардал	3,941.0	13,904.4	3,850.9
Бараа материал	1,486,280.3	1,418,964.5	1,418,779.2
Үндсэн хөрөнгө	22,646,636.3	21,068,788.0	16,665,070.5
Биет бус хөрөнгө	556,885.5	545,768.4	3,850.8
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>26,957,621.6</b>	<b>23,243,325.0</b>	<b>20,640,879.2</b>
Богино хугацаат өр төлбөр	989,592.7	58,739.4	124,155.9
Төрийн өмч	30,300,525.5	30,300,525.5	30,300,525.5
Эздийн өмчийн бусад хэсэг	564,079.2	1,614,953.0	2,460,565.8
Хуримтлагдсан үр дүн	(5,981,708.0)	(9,816,025.1)	(13,329,500.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,085,132.2	1,085,132.2	1,085,132.2
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>26,957,621.6</b>	<b>23,243,325.0</b>	<b>20,640,879.2</b>

*Мөнгөн хөрөнгийн талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2023 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 163,885.3 мянган төгрөг, кассын үлдэгдэл 1,295.0 мянган төгрөг, нийт мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн 165,180.3 мянган төгрөг, 2024 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,985,336.8

мянган төгрөг, кассын үлдэгдэл 3,020.8 мянган төгрөг, нийт мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн 1,988,357.6 мянган төгрөгөөс тус тус бүрдэж байна.

*Авлагын талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь 2023 оны жилийн эцсээр 44,623.8 мянган төгрөг, 2024 онд 28,452.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тус тус тайлагнажээ.

Хүснэгт 4.

Авлагын үлдэгдэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023.01.01	2023.12.31	2024.12.31	Тайлбар
Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар	239,990.3		-	Хонхтой цэцэрлэг (189,418.6 мянган төгрөгийн барьцаа, 24,583.4 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэл), Блю скай гадна талбайн тохижилтын ажил (25,988.2 мянган төгрөгийн барьцаа) 2023 онд барагдсан.
Ус сувгийн удирдах газар	799.2	276.8	184.7	Усны картын үлдэгдэл тооцооны авлага
Эхлэх үүд ХХК	17,917.5	17,917.5	17,917.5	Өвлийн хүлэмж барих ажлын шүүхийн шийдвэртэй авлага
Нийслэлийн татвар		4,317.3	-	Цалингаас үүссэн зөрүү ажилчдаас авах авлага
ЧД НДХэлтэс		45,463.0		НДШ-ийн тайлангийн зөрүү авлага
Нийслэлийн татварын газар	122,355.8			2023 онд барагдсан.
Нийслэлийн татварын газар	4,181.4	4,499.90	2,986.4	НӨАТ-ын авлага
Байгалмаа	3,512.5	3,512.5	3,512.5	Сити ОО түрээсийн авлага
Юнивишн	150.0	150.0		2023 онд барагдсан.
Шунхлай КУГ	3,941.0	13,904.4	3,850.9	Картын шатахууны урьдчилж төлсөн тооцооны авлага
<b>Нийт</b>	<b>392,697.6</b>	<b>44,623.8</b>	<b>28,452.0</b>	

Сити ОО түрээсийн 3,512.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.

*Бараа материалын талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь 2023 онд эхний үлдэгдэл 1,486,280.3 мянган төгрөг, 8,565,808.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 850,542.1 мянган төгрөгийн бараа материалд хөдөлгөөн хийж, 2,723,263.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй авч, 12,206,929.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, хөдөлгөөн хийж, 1,418,964.5 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл, 2024 онд 6,000,850.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 470,690.8 мянган төгрөгийн бараа материалд хөдөлгөөн хийн, 6,471,726.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, хөдөлгөөн хийж 1,418,779.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 5.

Бараа материалын тайлан

(мянган төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			Хасагдсан Зарцуулсан, хөдөлгөөн	Эцсийн үлдэгдэл
			Худалдан авсан	Хөдөлгөөн	Бусад		
2023 он							
1	Сэлбэг хэрэгсэл	176,941.1	1,215,571.4			1,188,890.3	203,622.2
2	Түлш, шатах тослох материал	268,998.4	3,791,276.5			3,862,949.9	197,325.0
3	Хангамжийн материал	1,040,340.7	3,558,961.0	850,542.1	2,723,263.0	7,155,089.6	1,018,017.2
	<b>Дүн</b>	<b>1,486,280.2</b>	<b>8,565,808.9</b>	<b>850,542.1</b>	<b>2,723,263.0</b>	<b>12,206,929.8</b>	<b>1,418,964.4</b>
2024 он							
1	Сэлбэг хэрэгсэл	203,622.2	611,998.1			764,846.6	50,773.7
2	Түлш, шатах тослох материал	197,325.0	1,931,359.9			1,554,273.2	574,411.7
3	Хангамжийн материал	1,018,017.2	3,457,492.7	470,690.8		4,152,607.0	793,593.7
	<b>Дүн</b>	<b>1,418,964.4</b>	<b>6,000,850.7</b>	<b>470,690.8</b>		<b>6,471,726.8</b>	<b>1,418,779.1</b>

*Үндсэн хөрөнгийн талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь 2023 онд эхний үлдэгдэл 37,661,246.3 мянган төгрөг, 52,776.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан, 1,070,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй авч, 457,903.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 49,379.5

мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 38,276,739.4 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэл, 2024 онд 143,854.5 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан, 1,010,640.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй авч, 8,765,007.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 4,285,547.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 26,380,679.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 6.

Үндсэн хөрөнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан		Эцсийн үлдэгдэл
			Худалдан авсан	Үнэ төлбөргүй	Шилжүүлсэн	акталсан	
2023 он							
1	Барилга байгууламж	10,093,808.2					10,093,808.2
2	Машин тоног төхөөрөмж	2,868,455.0				16,146.3	2,852,308.7
3	Тээврийн хэрэгсэл	18,867,955.6		1,070,000.0	457,903.4		19,480,052.2
4	Тавилга эд хогшил	306,178.0	38,284.5			13,195.1	331,267.4
5	Бусад үндсэн хөрөнгө	4,719,283.8					4,719,283.8
6	Компьютер	199,750.1	14,491.5			20,038.1	194,203.5
7	Биет бус хөрөнгө	605,815.6					605,815.6
	Дүн	37,661,246.3	52,776.0	1,070,000.0	457,903.4	49,379.5	38,276,739.4
2024 он							
1	Барилга байгууламж	10,093,808.2				19,379.8	10,074,428.4
2	Машин тоног төхөөрөмж	2,852,308.7	72,525.0	184,140.0	121,198.0	17,733.6	2,970,042.1
3	Тээврийн хэрэгсэл	19,480,052.2		826,500.0	8,641,161.6	4,152,449.0	7,512,941.6
4	Тавилга эд хогшил	331,267.4	13,515.9		2,647.8	27,314.3	314,821.2
5	Бусад үндсэн хөрөнгө	4,719,283.8	17,818.2			29,000.0	4,708,102.0
6	Компьютер	194,203.5	39,995.4			39,670.8	194,528.1
7	Биет бус хөрөнгө	605,815.6					605,815.6
	Дүн	38,276,739.4	143,854.5	1,010,640.0	8,765,007.4	4,285,547.5	26,380,679.0

НЗД, НӨХГ, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын тушаал шийдвэртэй тулгахад зөрүүтэй, 2024 онд 3,887,382.6 мянган төгрөгийн акталсан хөрөнгийг шилжүүлсэн гэж тайлагнаж, 890.2 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэргүйгээр зарлага болгосон байна.

Хүснэгт 7.

Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн 2024 оны тайлан

(мянган төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан		Эцсийн үлдэгдэл
			Худалдан авсан	Үнэ төлбөргүй	Шилжүүлсэн	акталсан	
1	Барилга байгууламж	10,093,808.2				19,379.8	10,074,428.4
2	Машин тоног төхөөрөмж	2,852,308.7	72,525.0	184,140.0	130,021.7		2,978,952.0
3	Тээврийн хэрэгсэл	19,480,052.2		826,500.0	12,520,610.7	273,000.0	7,512,941.5
4	Тавилга эд хогшил	331,267.4	13,515.9		2,647.8	27,314.3	314,821.2
5	Бусад үндсэн хөрөнгө	4,719,283.8	17,818.2			38,800.0	4,698,302.0
6	Компьютер	194,203.5	39,995.4			39,670.8	194,528.1
7	Биет бус хөрөнгө	605,815.6					605,815.6
	Дүн	38,276,739.4	143,854.5	1,010,640.0	12,653,280.2	398,164.9	26,379,788.8

Өр төлбөрийн талаар:

Тайлант 2023 онд өр төлбөр дансны үлдэгдэл 58,739.4 мянган төгрөгийн, 2024 онд 124,155.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тус тус тайлагнасан байна.

Хүснэгт 8.

Өглөгийн үлдэгдэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023.01.01	2023.12.31	2024.12.31
дансны өглөг	956,460.7	27,343.3	500.0
Татварын өглөг	33,132.0	31,396.1	123,655.9
Нийт	989,592.7	58,739.4	124,155.9

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь 2024 онд өмнөх оны өр төлбөрийн үлдэгдлийг бууруулсан боловч Нийслэлийн татварын газрын НӨАТ-ын өглөг 21.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 9.

Өр төлбөрийн дэлгэрэнгүй

(мянган төгрөгөөр)

Д/д	Байгууллагын нэр	Өглөгийн дүн		Тайлбар
		2023 он	2024 он	
1	Нийслэлийн татвар	4,409.4		ХАОАТ-ын өглөг
2	Нийслэлийн татвар	26,986.7	123,655.9	НӨАТ-ын өглөг
3	Асралт баян хайрхан ХХК	5,770.6		Өвлийн хувцасны барьцааны өглөг
4	Цац эрчис ХХК	3,617.0		Дугуйны тендерийн барьцааны өглөг
5	Баялаг өөдөс ХХК	16,475.7		Ногоон байгууламжийн хийцлэлийн барьцааны өглөг
6	Билгүүн	500.0	500.0	Сити ОО барьцааны өглөг
7	Доржсэмбэ	500.0		Сити ОО барьцааны өглөг
8	П.Туяа	480.0		Сити ОО барьцааны өглөг
	Нийт дүн	58,739.4	124,155.9	

**Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний талаар:**

Нийслэлийн засаг даргатай Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга 2023, 2024 онд НӨАУГ-тай контракт байгуулж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг батлуулан, гүйцэтгэлийг тайлагнан ажилласан байна.

НЗД-ын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/688 дугаар захирамжаар 2023 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлах, НӨХГ-ын даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 2/741 дүгээр захирамжаар 2023 нийт орлогыг 2,658,333.0 мянган төгрөг, зарлагыг 22,474,051.8 мянган төгрөг, алдагдлыг 2,301,989.5 мянган төгрөг, борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 1.11 төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 684,506.9 мянган төгрөг байхаар баталсан байна.

НЗД-ын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/755 дугаар захирамжаар 2024 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлах, НӨХГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 2/1187 дугаар захирамжаар 2024 нийт орлогыг 8,360,870.2 мянган төгрөг, зарлагыг 10,905,080.1 мянган төгрөг, алдагдлыг 2,544,209.9 мянган төгрөг, борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 1.11 төгрөг баталсан байна.

Хүснэгт 10

Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг жилээр нь харуулбал

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2023 он		2024 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого	18,833,880.5	27,265,000.8	7,683,060.7	15,743,049.0
	Түрээсийн орлого	0.0	8,155.5	0.0	5,879.5
	Хүүгийн орлого	0.0	3,716.0	0.0	9,044.8
	Үйл ажиллагааны бус орлого	1,338,181.8	1,422,511.0	677,809.5	2,218,916.3
	Нийт орлого	20,172,062.3	28,699,383.3	8,360,870.2	17,976,889.6
2	ББӨ	22,474,051.8	32,537,175.1	10,905,080.2	21,040,018.4
3	Нийт зардал	22,474,051.8	32,537,175.1	10,905,080.2	21,040,018.4
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-2,301,989.5	-3,837,791.8	-2,544,210.0	-3,063,128.8
5	Орлогын 1 төгрөгт ногдох зардал	1.11	1.13	1.30	1.17

2023 онд гүйцэтгэлээр 28,699,383.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 32,537,175.1 мянган төгрөгийн зардал гарган, 3,837,791.8 мянган төгрөгийн тайлант үеийн алдагдалтай ажилласан байна.

2024 онд гүйцэтгэлээр 17,976,889.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 21,040,018.4 мянган төгрөгийн зардал гарган, 3,063,128.73 мянган төгрөгийн тайлант үеийн алдагдалтай ажилласан байна.

Орлогын талаар:

Тайлант 2023 онд 20,172,062.3 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 28,699,383.1 мянган төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 142.2 хувь буюу 8,527,320.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Тайлант 2024 онд 8,360,870.2 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 17,976,889.6 мянган төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 215.0 хувь буюу 9,616,019.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 11. Зорилтот түвшний 2023, 2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл  
(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нийтийн эзэмшлийн зам талбайн өдөр тутмын цэвэрлэгээ	9,558,052.0	9,505,588.3	52,463.7	2,599,828.6	5,086,639.8	-2,486,811.2
Ногоон байгууламжийн тохижилт арчилгаа	3,223,214.3	3,212,112.2	11,102.1			0.0
Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааны зардал	4,464,285.7	4,464,285.7	0.0	4,464,285.7	6,639,412.2	-2,175,126.5
Төвлөрсөн хогийн цэгүүдийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил	235,714.3	235,714.3	0.0	235,714.3	235,714.3	0.0
Алтан-Өлгийн хүндэтгэлийн оршуулгын газрын арчлалт, хамгаалалтын ажил	126,535.7	126,535.7	0.0	126,535.7	181,964.2	-55,428.5
Сити тойлет, био ОО-ын ашиглалтын зардал	522,321.4	522,321.4	0.0			0.0
Нохой муурын сэг зэмийг шатаах, дарж булах ажлын зардал	267,857.2	207,169.5	60,687.7	256,696.4	215,881.4	40,815.0
Нийтийн эзэмшлийн зам талбайн агаар чийгшүүлэх, гудамж зам талбайн ариутгал, халдваргүйжүүлэлтийн санхүүжилт	190,364.2	190,364.1	0.1			0.0
Нийтийн эзэмшлийн сандал, хогийн сав будаж засварлах	22,321.4	22,321.4	0.0			0.0
Усан оргилууруудын арчлалт, хамгаалалт, ашиглалт, засвар үйлчилгээний ажил	223,214.3	223,214.3	0.0			0.0
Үйл ажиллагааны бусад орлого	1,338,181.8	1,434,382.4	-96,200.6	677,809.5	2,233,840.7	-1,556,031.2
Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурын ашиглалт, арчлалт, хамгаалалт, засвар үйлчилгээний санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0	267,857.1	-267,857.1
НЗД-ын захирамжаар эрх шилжиж ирсэн бүтээн байгуулалтын ажлууд	0.0	8,555,373.8	-8,555,373.8		3,115,579.9	-3,115,579.9
Нийт орлого	20,172,062.3	28,699,383.1	-8,527,320.8	8,360,870.2	17,976,889.6	-9,616,019.4

Тайлант 2023 оны зам талбайн өдөр тутмын цэвэрлэгээний санхүүжилтийн орлогын төлөвлөгөө 0.5 хувь буюу 52,463.7 мянган төгрөгөөр, ногоон байгууламжийн тохижилт арчилгааны санхүүжилтийн орлого 21.2 хувь буюу 60,687.7 мянган төгрөгөөр тус тус тасарсан хэдий ч нийт дүнгээр 42.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Тайлант 2024 оны зам талбайн өдөр тутмын цэвэрлэгээний санхүүжилтийн орлогын төлөвлөгөө 95.6 хувь буюу 2,486,811.2 мянган төгрөгөөр, төвлөрсөн хогийн цэгүүд дээр хийх хог дарж булах ажлын санхүүжилтийн орлого 48.7 хувь буюу 2,175,126.5 мянган төгрөгөөр, Алтан-Өлгийн арчлалт, хамгаалалтын санхүүжилтийн орлого 43.8 хувь буюу 55.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 30.3 хувь буюу 1,556,031.2 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн.

Хүснэгт 12. Бусад орлогын гүйцэтгэлийн задаргаа  
(мянган төгрөгөөр)

№	Үйл ажиллагааны бусад орлого	2023 он	2024 он
1	Хог хаягдлын орлого	1,033,486.0	1,326,824.4
2	Түрээсийн орлого	8,155.5	5,879.5
3	Харилцах дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого	3,716.0	9,044.8
4	Засгийн буцалтгүй тусламжийн орлого	19,126.2	165,027.3

5	Бусад орлого/био 00-ийн үйлчилгээ, хог ачилт, цэвэрлэгээ үйлчилгээ/	177,232.2	451,786.2
6	Хангамжийн материалын худалдан авалт /ЗАА-с/	15,338.1	
7	Асем вилагийн ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилт	62,499.9	
8	Үндэсний баяр наадмын үеийн цэвэрлэгээ, хүй 7 худгийн усалгааны ажил	32,633.8	
9	Гамшгийн үерийн үед лаг шавар, хайрга, дайрга тээвэрлэх болон гамшгийн дараах ариутгал, халдваргүйтгэл	82,194.7	
10	Үндэсний баяр наадмын үеийн цэвэрлэгээ, хүй 7 худгийн усалгааны ажил		17,635.9
11	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		52,212.9
12	Сэлбэ дэд төвийн цэвэрлэгээний төлбөр		205,429.7
	Нийт дүн	1,434,382.4	2,233,840.7

Зардлын талаар:

Тус газар нь 2023 онд 22,474,051.7 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 32,537,175.0 мянган төгрөгийн зардал гарган, 10,063,123.3 мянган төгрөг, 2024 онд 10,905,079.5 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 21,040,017.4 мянган төгрөгийн зардал гарган, 10,134,937.9 мянган төгрөгийг тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 13.

Зорилтот түвшний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +/-, хэмнэлт -/-	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +/-, хэмнэлт -/-
Цалин	11,150,923.5	10,236,345.9	914,577.6	3,753,996.5	5,670,706.4	-1,916,709.9
НДШ	1,616,883.9	1,481,195.9	135,688.0	544,329.5	750,927.0	-206,597.5
Удирдах зөвлөлийн зардал	45,342.0	45,342.0	0.0	54,410.0	54,410.0	0.0
Ашиглалтын зардал	374,593.7	433,547.5	-58,953.8	267,359.0	91,987.9	175,371.1
Түрээсийн зардал	156,150.0	110,653.8	45,496.2	24,000.0	10,616.2	13,383.8
Тос масло тосолгооны зардал	171,452.0	177,241.9	-5,789.9	121,627.0	76,059.6	45,567.4
Машин техник сэлбэг хэрэгсэл	714,198.5	966,486.6	-252,288.1	138,084.0	497,312.6	-359,228.6
Хөдөлмөр хамгаалал	222,967.2	227,015.8	-4,048.6	40,976.2	91,093.3	-50,117.1
Багаж хэрэгслийн зардал	137,451.5	249,002.2	-111,550.7	46,120.0	17,829.0	28,291.0
хангамжийн зардал	268,595.5	2,401,001.9	-2,132,406.4	177,733.0	2,878,453.9	-2,700,720.9
Дулааны зардал /хийн түлш/	0.0	0.0	0.0	243,997.6	231,335.5	12,662.1
Цэвэрлэгээний материал	56,225.3	111,032.6	-54,807.3	18,025.6	255,642.0	-237,616.4
ТЭМ-Ногоон байгууламж	722,969.0	714,859.8	8,109.2	0.0	0.0	0.0
Зар сурталчилгааны зардал	25,522.7	12,090.9	13,431.8	25,522.7	0.0	25,522.7
Албан томилолтын зардал	0.0	21,090.9	-21,090.9	0.0	0.0	0.0
Шуудан холбооны зардал	21,660.0	17,790.5	3,869.5	21,660.0	17,009.4	4,650.6
Бичиг хэргийн зардал	26,476.2	30,008.7	-3,532.5	17,333.9	14,032.8	3,301.1
Шатахууны зардал	3,439,341.4	3,511,488.0	-72,146.6	2,302,188.1	1,478,795.9	823,392.2
Нийгмийн арга хэмжээний зардал	256,475.0	203,265.3	53,209.7	291,575.0	516,936.1	-225,361.1
Сургалтын зардал	57,800.0	2,650.0	55,150.0	35,600.0	38,340.0	-2,740.0
Үндсэн хөрөнгийн элэгдэл	2,408,955.5	2,561,235.6	-152,280.1	2,497,348.4	2,100,237.4	397,111.0
ШБОС албан хаагчдад урамшуулал	33,000.0	0.0	33,000.0	0.0	0.0	0.0
Онцгой үеийн зардал /Цэр тахал/	65,340.0	0.0	65,340.0	0.0	0.0	0.0
Бусад зардал	501,728.8	961,952.9	-460,224.1	283,193.0	4,168,478.9	-3,885,285.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	0.0	8,061,876.3	-8,061,876.3	0.0	2,079,813.5	-2,079,813.5
Нийт зардал	22,474,051.7	32,537,175.0	-10,063,123.3	10,905,079.5	21,040,017.4	-10,134,937.9

Тайлант 2023 оны нийт зардлын 36.0 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 10.7 хувийг шатахууны зардал, 7.8 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 11.3 хувийг сэлбэг хэрэгсэл, шуудан холбоо, сургалт, бичиг хэрэг, албан томилолт, багаж хэрэгсэл, хангамж, цэвэрлэгээний зардал тус тус эзэлж байна.

Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/05 тушаалаар цалин хөлсийг 50 хувиар нэмэгдүүлсэн байна.

Ашиглалтын зардал, машин техник сэлбэг хэрэгслийн зардал, тос масло тосолгооны зардал, багаж хэрэгслийн зардал, цэвэрлэгээний зардал, бичиг хэргийн зардал, шатахууны зардал, бусад зардал хэтэрсэн байна.

Цалин, НДШ, түрээсийн зардал, хөдөлмөр хамгааллын зардал, сургалтын зардал, албан хаагчдад олгох урамшуулал, онцгой үеийн зардал, түрээс, зар сурталчилгаа, хэвлэл, интернэт, харилцаа холбооны зардлыг тус тус хэмнэсэн байна.

Тайлант 2024 оны нийт зардлын 30.5 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 0.7 хувийг шатахууны зардал, 0.9 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 19.8 хувийг бусад зардал, 17.6 хувийг сэлбэг хэрэгсэл, шуудан холбоо, сургалт, бичиг хэрэг, албан томилот, багаж хэрэгсэл, хангамж, цэвэрлэгээний зардал тус тус эзэлж байна.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, машин техник сэлбэг хэрэгслийн зардал, хөдөлмөр хамгаалал, хангамжийн материал, нийгмийн арга хэмжээний зардал, сургалтын зардал, бусад зардал хэтэрсэн байна.

2024 онд нийт орлого нэмэгдсэнээр нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ, төвлөрсөн хогийн цэгүүдийн хүнд нөхцөлд ажиллаж буй албан хаагчдын үндсэн цалинг 3,500.0 мянган төгрөг, бусад албан хаагчдын цалин хөлсийг 50 хувиар нэмэгдүүлсэн зэрэг нь нийт зардал өсөх эх үүсвэр болсон байна.

*Санхүүгийн хяналт шалгалтын явцад хийсэн ажил:*

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төсөл, европын холбооны буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төслийн хүрээнд 29 машин механизм дагалдах хэрэгслийг хүлээн авсан ч шийдвэр ирээгүй нэрийдлээр хөрөнгөд бүртгээгүй, хөрөнгөд бүртгээгүй тээврийн хэрэгслийг байгууллагын нэрээр гэрчилгээжүүлсэн байна. 1 тээврийн хэрэгслийн гэрчилгээг Нийслэлийн хяналт шалгалтын газрын нэр дээр шилжүүлэн өгсөн. Хөрөнгөд бүртгэлгүй тээврийн хэрэгсэлд 379268 литр буюу 1,198,124.3 мянган төгрөгийн шатахуун, 17,562.0 мянган төгрөгийн тос тослох материал, 55,080.2 мянган төгрөгийн сэлбэг зарцуулсан, мөн 2024 онд тус тээврийн хэрэгслүүдэд засвар үйлчилгээ хийхээр худалдан авах ажиллагааг зарлан явуулсан байна. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын нэр дээр гэрчилгээтэй 16 автомашин, дагалдах хэрэгслийг шийдвэргүйгээр Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-т /акт үйлдэж хүлээлцээгүй/ өгсөн байна.

НЗД-ын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн "Тээврийн хэрэгсэл данснаас хасах тухай" А/757 дугаар захирамжаар Техникийн комиссын дүгнэлтээр цаашид ашиглах боломжгүй нь тогтоогдсон 3,879,449.0 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, 993,212.8 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 28 тээврийн хэрэгслийг данснаас хасаж, 436,336.2 мянган төгрөгөөр худалдан борлуулах үүрэг болгосноор өнөөдрийг хүртэл 24 тээврийн хэрэгслийг худалдан борлуулсан байна.

Нийт 28 тээврийн хэрэгслээс 24 тээврийн хэрэгслийг худалдан борлуулж Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дансанд 202,867.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 114,269.3 мянган төгрөг, НӨХГ-ын дансанд 87,023.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 49,052.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ч борлуулагдсан 15 тээврийн хэрэгсэл байгууллагын нэр дээр бүртгэлтэй байна. НӨХГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/127 дугаар тушаалаар авто тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-т үүрэг болгосныг хэрэгжүүлээгүй байна.

НЗД-ын 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/757 дугаар захирамжаар данснаас хасагдаж байгаа тээврийн хэрэгслийг сэлбэг болон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахыг НӨХГ-т даалгасан боловч өнөөдрийг хүртэл 126,569.4 мянган төгрөгийн худалдан борлуулах доод үнэ бүхий 4 тээврийн хэрэгсэл борлуулагдаагүй, хөрөнгө эзэнгүйдэх нөхцөлийг бүрдүүлсэн, эргэн хяналт тавьж ажиллаагүй байна.

Хүснэгт 14.

Бүртгэлээс хасагдсан хөрөнгө

(мянган төгрөгөөр)

№	Хөрөнгө нэр	Улсын дугаар	Ашиглалтад орсон огноо	2024.06.24 А/757				2025.05.07 А/645
				Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Худалдан борлуулах доод үнэ	Худалдан борлуулах доод үнэ
1	Ачааны машин /Dongfeng/	69-03УНУ	2017	111,332.2	74,231.6	37,100.6	24,040.0	14,424.0
2	Самосвол /10 тн, миц фусо/	72-48УБЕ	2008	75,786.2	75,786.2	-	23,367.0	14,020.2
3	Эксковатор	70-16 УБ	2013	265,754.8	265,754.8	-	54,167.0	32,500.2
4	Эксковатор /комацу япон/	87-01УН	2008	143,820.8	143,820.8	-	109,375.0	65,625.0
				596,694.0	559,593.4	37,100.6	210,949.0	126,569.4

Санхүүгийн шинжилгээний талаар:

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2023 он, 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн үзүүлэлтэд үндэслэн санхүүгийн шинжилгээний горимыг гүйцэтгэлээ.

Хүснэгт 15.

Санхүүгийн шинжилгээ

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31	Тайлбар
1.Төлбөрийн чадварын үзүүлэлт			
Эргэлтийн харьцаа	115.53	725.18	Энэ нь богино хугацаат өр төлбөрийг барагдуулах бүрэн боломжтой байна
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	59,11	438,82	Төлбөр барагдуулах ойрын боломж сайн байна.
2. Ашигт ажиллагааны үзүүлэлт			
Борлуулалтын өгөөж	-0.019	-0.093	Борлуулалтын өгөөж буурсан
Хөрөнгийн өгөөж	-0.015	-0.048	0.033 төгрөгөөр өгөөж буурсан
Цэвэр активын өгөөж	-0.015	-0.048	Өгөөж буурсан
3. Өрийн хөшүүрэг			
Өрийн харьцаа	0.001	0.0002	Нийт хөрөнгийн өр буурсан
Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа	0.001	0.0002	Өрийн хувийн жин буурсан.
4. Нийт хөрөнгийн ашиглалтын үзүүлэлт			
Дансны авлагын эргэц	12.8	31.78	Жилд 31.78 хугацаанд авлага цуглуулах боломжтой
Авлага цуглуулах хугацаа	28.5	11.48	Авлага цуглуулах дундаж хугацаа 11.48 болсон байна.
5. Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт			
Бие даах чадварын коэффициент	0.99	0.99	Бие даах чадварын коэффициент зохистой харьцаанд буюу өөрийн санхүүжилтээр бие даан үйл ажиллагаа явуулах чадвартай
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.01	1.08	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал өссөн байна.

### Зорилт 3. Худалдан авах ажиллагааны талаар

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь 2023 онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар (НТША) 12, харьцуулалтын тендер аргаар 7, шууд худалдан авалтаар (ШХА) 66 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар 7,003,651.2 мянган төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр нээлттэй тендер 12, харьцуулалтын аргаар (ХА) 7 худалдан авалтыг 5,047,061.8 мянган төгрөгийн ажил үйлчилгээ, худалдан авалтыг өөрийн хөрөнгөөр хийсэн байна.

2023 онд төвлөрсөн хогийн цэгүүдийн менежмент, хүчин чадлыг сайжруулахтай холбоотойгоор ЦДТХЦэгийн оффисын байрны дээвэр болон дотор засвар хийх ажлын тендер үр дүн гарсан ч хойшлогдсон. Ажилчдын автобус нийлүүлэх, Төвлөрсөн хогийн цэгүүдэд замын гэрэлтүүлгийн ажил, Чарганы сэлбэг, Мод үржүүлгийн газрын хашаа барих ажил, Мод үржүүлгийн газар худаг гаргах ажил, Мод үржүүлгийн газрын цахилгааны монтажны ажил зэрэг тендерүүдэд оролцогч байхгүй тул амжилтгүй болсон байна.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь 2024 онд нээлттэй тендерийн аргаар 5, харьцуулалтын тендер аргаар 1, шууд худалдан авалтаар 65 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар 3,928,320.1 мянган төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр нээлттэй тендер 5, харьцуулалтын аргаар 1 худалдан авалтыг 3,108,506.9 мянган төгрөгийн ажил үйлчилгээ, худалдан авалтыг өөрийн хөрөнгөөр хийсэн байна.

Хүснэгт 16.

Худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

Худалдан авалтын төрөл	2023 он				2024 он			
	тоо	төлөвлөгөө	тоо	гүйцэтгэл	тоо	төлөвлөгөө	тоо	гүйцэтгэл
Нээлттэй тендер	12	5,574,956.0	9	4,918,378.0	5	3,438,160.8	5	3,057,206.9
Харьцуулалт арга	7	451,477.4	3	128,683.7	1	66,000.0	1	51,300.0
Шууд худалдан авалт	66	977,217.8			65	424,159.3		
Нийт дүн	85	7,003,651.2	12	5,047,061.7	71	3,928,320.1	6	3,108,506.9

Тайлант 2023 онд нийт худалдан авалтын 13.7 хувийг хангамжийн материал, 20.1 хувийг шатахуун, 4.1 хувийг ногоон байгууламжийн түүхий эд материал, 5.5 хувийг сэлбэг хэрэгсэл эзэлж байгаа бол үлдсэн 56.6 хувийг бусад ажил, худалдан авалтууд эзэлж байна.

Тайлант 2024 онд нийт худалдан авалтын 24.9 хувийг хангамжийн материал, 12.7 хувийг шатахуун, 4.3 хувийг сэлбэг хэрэгсэл эзэлж байгаа бол үлдсэн 58.1 хувийг бусад ажил, худалдан авалтууд эзэлж байна.

*Санхүүгийн үйл ажиллагааны талаар:*

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоо шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус газрын Санхүү, бүртгэлийн хэлтэс, Эдийн засаг хангамжийн хэлтэс нэгдэн Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтэс болж 9 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тус газар нь санхүүгийн үйл ажиллагаандаа Даймонд программ, цалингийн үйл ажиллагаанд Payroll программыг ашиглаж байна.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын тушаалаар 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг (НБББББ) баталсан байна. Тус НБББББ-ийг хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтийг тусгах, зарим зүйл заалт нь шаардлага хангахгүй болсон тул шинэчлэх шаардлагатай байна.

### ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Дотоод аудит, хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. БНХАУ-д албан томилолтоор ажилласан 5 албан хаагчийн онгоцны тийзний үнэ болох 9,459.5 мянган төгрөгийг Аэрмаркет холидэй ХХК-руу шилжүүлэн зарлага болгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.2.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ; гэсэн заалтыг зөрчсөн байна.
2. БНХАУ-ын 2 удаагийн албан томилолтын хугацаа, зорилго өөр байхад хамтад нь ажилласан байдлаар 1 тайлан бичсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; гэсэн заалтыг зөрчсөн байна.
3. Худалдан авсан 19,058.9 мянган төгрөгийн хүнсний бараа материалыг бөөн дүнгээр нь орлого авч, зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; гэсэн заалт, НББОУС 2 мөрдөж ажиллаагүй байна.
4. Цагаан сарын баярыг тохиолдуулан эмэгтэй 50 нас, эрэгтэй 55 наснаас дээш тэтгэврийн насанд хүрээгүй ажилтнуудад 40,590.0 мянган төгрөгийг зарцуулахаар шийдвэр гарган, зарлага болгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай,

хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Ахмад настны тухай хуулийн 3.1.Энэ хуулийн үйлчлэлд 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн хамаарна; гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

5. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь албан хаагчдын бэлгэнд 2023 онд 16,320.0 мянган төгрөг, 2024 онд 41,238.0 мянган төгрөг, нийт 57,558.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах; гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.
6. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын газар нь 2023 оны 06 дугаар сарын 09-нд 4,950.0 мянган төгрөгөөр /15\*330.0/ хонь авч Тохижилт үйлчилгээний алба, Ногоон байгууламжийн албаны аяллын зардалд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.
7. Жолоочийн тооцооны хуудсаар ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргаагүй байхад, А-92 маркийн 7313.5 литр 15,820.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3."анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно; 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; гэсэн заалт, Монгол улсын зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаал, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Шатахуун зарцуулалтын норм шинэчлэн батлах тухай А/51 дүгээр тушаалуудыг мөрдөж ажиллаагүй байна.
8. ТУЗ нь 2023 оны 02 дугаар сард буюу эхний улиралд хуралдаж, бусад улиралд хуралдаагүй байхад 2, 3, 4 улирлын цалин 22,550.0 мянган төгрөгийг олгож, мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 54 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам"-ын 3.2.Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа заавал хуралдуулах бөгөөд хуралд нийт гишүүдийнх нь олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно. Удирдах зөвлөлийн хуралд гишүүд биеэр оролцох үүрэгтэй; 6.3.2.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Удирдах зөвлөлийн хуралд биеэр оролцоогүй, нийслэлийн өмчийн төлөөлөгчийн үүрэгтэй холбогдсон ажил үүргээ гүйцэтгээгүй нөхцөлд тухайн сард ногдох цалинг олгохгүй" гэснийг зөрчсөн байна.
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн 4 гишүүнд нийт 6,160.0 мянган төгрөгийн цалинг илүү олгож, мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэргүй, дарга өөртөө урамшуулал олгохоор тушаал үйлдэж, урамшуулалд 11,598.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 40.4.2.хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

тухай хуулийн 11.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно; гэсэн заалтууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 54 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 5.4.Төлөөлөн удирдах зөвлөл нь нийслэлийн өмч давамгайлсан хувьцаат компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, гэрээний биелэлтэд дүгнэлт гаргаж, гүйцэтгэх захиралд олгох урамшуулал, хүлээлгэх хариуцлагын талаар шийдвэр гаргана” гэснийг зөрчсөн байна.

11. НЗДТГ-аас шийдвэр ирээгүй байхад хоёрдугаар гарын үсэг зурж буй албан тушаалтан, тооцооны нягтлан бодогч нарт нэг сарын үндсэн цалин болох 7,620.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. (НЗДТГ-аас ирсэн шийдвэрийн дагуу 2024 оны 06 дугаар сард тушаал гарган олгосон болно) Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
12. Тохижилт үйлчилгээний ажилтны өдрөөр анхан шатны баримтгүйгээр албан хаагчдын бэлгэнд гэж 942.2 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
13. Дүүргүүдэд шилжүүлэхээр шийдвэр гарган 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр данс бүртгэлээс хассан тээврийн хэрэгсэлд 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр 426,1 мянган төгрөгийн тос тослох материал, 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр актлагдаж данс бүртгэлээс хасагдсан тээврийн хэрэгслийн худалдан борлуулалтын үнэ 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр орж ирсэн байхад тэр хугацаанаас хойш 486.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан гэж зарлага гарган, нийт 912.9 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
14. Номин бизнес клубаас 170 ширхэг бэлгийг худалдан авсан боловч жагсаалтаар 164 хүүхдэд бэлэг тарааж, 6 бэлэг буюу 353.9 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3.“анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно; 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
15. Тасралтгүй 12 сар ажиллаагүй Диспетчер О.Энхзулд 1,737.4 мянган төгрөгийн урамшуулалт цалинг илүү тооцон олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтууд, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/105 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Шагнал, урамшуулалт цалин олгох журам”-ын 1.2.Шагнал, мөнгөн урамшууллыг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Газрын даргын тушаалаар батална; 2.2.Тухайн жилд ажилтан нь тасралтгүй 12 сар ажилласан байх бөгөөд ажилласан хугацаандаа үр бүтээлтэй, санаачилгатай ажилласныг харгалзан үзэж урамшуулалт цалинг хувиар тооцож олгож болно; 2.4.Тухайн жилдээ хөдөлмөрийн гэрээг цуцалж ажлаас чөлөөлөгдөөд эргэн ажилдаа орсон, хүүхэд асрах болон хувийн чөлөөтэй байсны улмаас 12 сар хүрээгүй ажилтнуудад урамшуулалт цалин олгохгүй; гэснийг зөрчсөн байна.

## ДҮГНЭЛТ

Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил давтагдан акталсан буюу эвдэрсэн машинд шатахуун, сэлбэг, шатах тослох материал зарцуулсан байна.

НҮБ-ын буцалтгүй тусламжаар Цагаан давааны төвлөрсөн хогийн цэг дээр баригдсан 1,982,241.3 мянган төгрөгийн өртөгтэй Үнс булах ланфиллийн байгууламжийг НӨАУГ-ын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 2/1090 тоот албан бичгээр тус газарт хүлээлгэн өгч данс бүртгэлд бүртгэж авсан хэдий ч өнөөдрийг хүртэл ашиглагдаагүй хэвээр байна.

НИТХ-аас гарч буй “Удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөх тухай” тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар НӨХГ нь 3 сарын дараа байгууллагад албан бичгийг хүргүүлснээр Удирдах зөвлөлийн дарга гишүүдэд цалин илүү олгох зөрчлийг бий болгож байна.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-т хийсэн хяналт шалгалтаар 180,093.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 10,106.4 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн төлбөрийн акт тогтоон, 169,986.8 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэн, үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч байна.

## ЗӨВЛӨМЖ

Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн асуудалд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. НБББББ-ийг байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, ажиллах;
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, ТБОНӨХБАҮХАТ хууль, НББОУС, санхүү бүртгэлтэй холбоотой холбогдох журам, шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллах;
3. Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, нярав нар эрх үүргээ хэрэгжүүлж ажиллах;
4. НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах;
5. Төлөөлөн удирдах зөвлөл эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллах;
6. НӨХГ нь ТУЗ-ийн дарга, гишүүдийг томилсон, чөлөөлсөн шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлэх;


Зөвлөмжийг хэрэгжүүлж хэрэгжилтийн тайланг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор нийслэлийн Дотоод аудитын албанд ирүүлэхийг мэдэгдэж байна.

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН  
ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН  
АЛБАНЫ ДАРГА

ХЯНАСАН:

АУДИТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ (СХШУАБ)



З.ОТГОНБАЯР

Д.НАНСАЛМАА

БЭЛТГЭСЭН:

АУДИТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ ДОТООД АУДИТОР (СХШУАБ)



Д.МӨНХХАНД

АУДИТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДОТООД АУДИТОР



А.ГЭРЛЭЭ

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:  
ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ



Г.УУГАНБАЯР

Б.ДАВААСҮРЭН



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
АКТ

Наадамчдын зам 1200, Арцатын ам,  
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот, 17100  
Утас: (976) 7010 1388, 7010 1408

Цахим шуудан: [contact@internalaudit.ub.gov.mn](mailto:contact@internalaudit.ub.gov.mn)  
Цахим хуудас: [www.internalaudit.ub.gov.mn](http://www.internalaudit.ub.gov.mn)

2025.11.25 № 38/09-79

Зориулалт бусаар зарцуулсан мөнгөн  
хөрөнгийг төсөвт төвлөрүүлэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан 14 дүгээр удирдамжийн дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд нийслэлийн Дотоод аудитын албаны аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд, дотоод аудитор А.Гэрлээ нар 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн ажлын 25 хоногт багтаан хяналт шалгалт хийлээ.

Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэж тус тус заасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн 4 гишүүнд нийт 6,160.0 мянган төгрөгийн цалинг илүү олгож, мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

ТОГТООХ НЬ:

НЭГ.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалтыг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан 6,160.0 мянган төгрөгийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Б.Мөнхцэцэг, хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Оюунсүрэн нараар хариуцуулан төлүүлж нийслэлийн төсвийн орлогод төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

ХОЁР.Төлбөрийн 6,160.0 мянган төгрөгийг Төрийн сан УБ.Хүү торгуулийн орлого 100200000988 тоот дансанд 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор оруулахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Г.Ууганбаяр, хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэн нарт хариуцуулав.

ГУРАВ.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д заасны дагуу 6,160.0 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэн, санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгахыг

хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэнд хариуцуулав.

ДӨРӨВ.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ  
БАЙЦААГЧ

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:  
ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ОНӨААТУГ-ЫН  
ДАРГА

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ



Д.МӨНХХАНД

Г.УУГАНБАЯР

Б.ДАВААСҮРЭН



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
АКТ

Наадамчдын зам 1200, Арцатын ам,  
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот, 17100

Утас: (976) 7010 1388, 7010 1408

Цахим шуудан: [contact@internalaudit.ub.gov.mn](mailto:contact@internalaudit.ub.gov.mn)

Цахим хуудас: [www.internalaudit.ub.gov.mn](http://www.internalaudit.ub.gov.mn)

2025.11.25 № 38/09-80

Илүү олгосон мөнгөн хөрөнгийг  
төсөвт төвлөрүүлэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан 14 дүгээр удирдамжийн дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд нийслэлийн Дотоод аудитын албаны аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд, дотоод аудитор А.Гэрлээ нар 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн ажлын 25 хоногт багтаан хяналт шалгалт хийлээ.

Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтууд, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/105 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Шагнал, урамшуулалт цалин олгох журам"-ын 1.2.Шагнал, мөнгөн урамшууллыг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Газрын даргын тушаалаар батална; 2.2.Тухайн жилд ажилтан нь тасралтгүй 12 сар ажилласан байх бөгөөд ажилласан хугацаандаа үр бүтээлтэй, санаачилгатай ажилласныг харгалзан үзэж урамшуулалт цалинг хувиар тооцож олгож болно; 2.4.Тухайн жилдээ хөдөлмөрийн гэрээг цуцалж ажлаас чөлөөлөгдөөд эргэн ажилдаа орсон, хүүхэд асрах болон хувийн чөлөөтэй байсны улмаас 12 сар хүрээгүй ажилтнуудад урамшуулалт цалин олгохгүй; гэж тус тус заасан байна.

Тасралтгүй 12 сар ажиллаагүй Диспетчер О.Энхзулд 1,737.4 мянган төгрөгийн урамшуулалт цалинг илүү тооцон олгосон зөрчил илэрлээ.

ТОГТООХ НЬ:

НЭГ.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтууд, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/105 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Шагнал, урамшуулалт цалин олгох журам"-ын 1.2.Шагнал, мөнгөн урамшууллыг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Газрын даргын тушаалаар батална; 2.2.Тухайн жилд ажилтан нь тасралтгүй 12 сар ажилласан байх бөгөөд ажилласан хугацаандаа үр

1725040201

бүтээлтэй, санаачилгатай ажилласныг харгалзан үзэж урамшуулалт цалинг хувиар тооцож олгож болно; 2.4.Тухайн жилдээ хөдөлмөрийн гэрээг цуцалж ажлаас чөлөөлөгдөөд эргэн ажилдаа орсон, хүүхэд асрах болон хувийн чөлөөтэй байсны улмаас 12 сар хүрээгүй ажилтнуудад урамшуулалт цалин олгохгүй; заалтыг үндэслэн илүү тооцон олгосон 1,737.4 мянган төгрөгийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Б.Мөнхцэцэг, хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Оюунсүрэн нараар хариуцуулан төлүүлж нийслэлийн төсвийн орлогод төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

ХОЁР.Төлбөрийн 1,737.4 мянган төгрөгийг Төрийн сангийн УБ.Хүү торгуулийн орлого 100200000988 тоот дансанд 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор оруулахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Г.Ууганбаяр, хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэн нарт хариуцуулав.

ГУРАВ.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д заасны дагуу 1,737.4 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэн, санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгахыг хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэнд хариуцуулав.

ДӨРӨВ.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ  
БАЙЦААГЧ

Д.МӨНХХАНД

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:  
ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА

Г.УУГАНБАЯР

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ

Б.ДАВААСҮРЭН





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
АКТ

Наадамчдын зам 1200, Арцатын ам,  
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот, 17100

Утас: (976) 7010 1388, 7010 1408

Цахим шуудан: [contact@internalaudit.ub.gov.mn](mailto:contact@internalaudit.ub.gov.mn)

Цахим хуудас: [www.internalaudit.ub.gov.mn](http://www.internalaudit.ub.gov.mn)

2025.11.25 № 38/09-81

Үр ашиггүй зарцуулсан мөнгөн  
хөрөнгийг төсөвт төвлөрүүлэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан 14 дүгээр удирдамжийн дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд нийслэлийн Дотоод аудитын албаны аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд, дотоод аудитор А.Гэрлээ нар 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн ажлын 25 хоногт багтаан хяналт шалгалт хийлээ.

Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3."анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно; 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; гэж тус тус заасан байна.

Анхан шатны баримтгүйгээр Тохижилт үйлчилгээний ажилтны өдрөөр албан хаагчдын бэлгэнд гэж 942.2 мянган төгрөг, Номин бизнес клубаас 170 ширхэг хүүхдийн бэлгийг худалдан авсан боловч жагсаалтаар 164 хүүхдэд бэлэг тарааж, 6 бэлэг буюу 353.9 мянган төгрөг, нийт 1,296.1 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ.

ТОГТООХ НЬ:

НЭГ.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3."анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно; 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; заалтыг үндэслэн үр ашиггүй зарцуулсан 1,296.1 мянган төгрөгийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Б.Мөнхцэцэг, хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Оюунсүрэн нараар хариуцуулан төлүүлж нийслэлийн төсвийн орлогод төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

1725040203

ХОЁР.Төлбөрийн 1,296.1 мянган төгрөгийг Төрийн сангийн УБ.Хүү торгуулийн орлого 100200000988 тоот дансанд 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор оруулахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Г.Ууганбаяр, хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэн нарт хариуцуулав.

ГУРАВ.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д заасны дагуу 1,296.1 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэн, санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгахыг хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэнд хариуцуулав.

ДӨРӨВ.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ  
БАЙЦААГЧ

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ



Д.МӨНХХАНД

Г.УУГАНБАЯР

Б.ДАВААСҮРЭН



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
АКТ

Наадамчдын зам 1200, Арцатын ам,  
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот, 17100

Утас: (976) 7010 1388, 7010 1408

Цахим шуудан: [contact@internalaudit.ub.gov.mn](mailto:contact@internalaudit.ub.gov.mn)

Цахим хуудас: [www.internalaudit.ub.gov.mn](http://www.internalaudit.ub.gov.mn)

2025.11.25 № 38/09-82

Зориулалт бусаар зарцуулсан мөнгөн  
хөрөнгийг төсөвт төвлөрүүлэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан 14 дүгээр удирдамжийн дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд нийслэлийн Дотоод аудитын албаны аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд, дотоод аудитор А.Гэрлээ нар 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн ажлын 25 хоногт багтаан хяналт шалгалт хийлээ.

Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэж тус тус заасан байна.

Дүүргүүдэд шилжүүлэхээр шийдвэр гарган 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр данс бүртгэлээс хассан тээврийн хэрэгсэлд 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр 426,1 мянган төгрөгийн тос тослох материал, 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр актлагдаж данс бүртгэлээс хасагдсан тээврийн хэрэгслийн худалдан борлуулалтын үнэ 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр орж ирсэн байхад тэр хугацаанаас хойш 486.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан гэж зарлага гарган, нийт 912.9 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

ТОГТООХ НЬ:

НЭГ.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалтыг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан 912.9 мянган төгрөгийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Б.Мөнхцэцэг, хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Оюунсүрэн нараар хариуцуулан төлүүлж нийслэлийн төсвийн орлогод төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

ХОЁР.Төлбөрийн 912.9 мянган төгрөгийг Төрийн сангийн УБ.Хүү торгуулийн орлого 100200000988 тоот дансанд 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор оруулахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга Г.Ууганбаяр, хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэн нарт хариуцуулав.

1725040205

ГУРАВ.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д заасны дагуу 912.9 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэн, санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгахыг хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэнд хариуцуулав.

ДӨРӨВ.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ  
БАЙЦААГЧ

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:  
ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ



Д.МӨНХХАНД

Г.УУГАНБАЯР

Б.ДАВААСҮРЭН